

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

Засаг даргын зөвлөлийн хурал 2 удаа хуралдаж 4 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Үүнд: Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн дүн, төсвийн шууд захирагчдын гүйцэтгэлийн үнэлгээг хэлэлцэж, оны онцлох байгууллага болон онцлох хүнийг шалгаруулсан. Мөн аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагнуулах иргэдийн материалтай танилцаж шийдвэрлэсэн байна.

2020 оны 12 дугаар сарын 25 ны өдөр 2020 онд ажил үйлс, амжилтаараа манлайлсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын шагнал гардуулах үйл ажиллагааг зохион байгуулсан. Үүнд: “Оны онцлох байгууллага”-аар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425 дугаар нээлттэй хорих анги, “Дэлхийн зөн Монгол” ОУБ-ын Бор-Өндөр орон нутгийн хөтөлбөр, Боржигин өв музей шалгарсан. Ажил үйлс амжилтаараа хамт олноо манлайлан ажилласан 6 хүнийг “Оны онцлох хүн”-ээр, 13 хүнийг аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр тус тус шагнаж урамшуулсан.

Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд: Аймгийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/333 дугаар захирамжаар батлагдсан ажлын хэсэг 12 дугаар сарын 15-ны өдөр аймгийн хэмжээний 5 дахь удаагийн эрсдэлийн үнэлгээг хийхэд “Маш өндөр эрсдэл”-тэй үнэлэгдэж, 15 заалт бүхий зөвлөмж боловсруулж аймгийн Онцгой комисст танилцуулсан.

COVID 19 халдварыг илрүүлэх түргэвчилсэн шинжилгээнд 9256 иргэнийг хамруулж, PCR шинжилгээг 3457 удаа хийсэн байна.

Коронавируст халдварын эмчилгээнд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлын нөөц аймгийн эрүүл мэндийн байгууллагуудад дунджаар 85 хувь, эмийн сангуудын зайлшгүй шаардлагатай эмийн хангалт 80 хувь, 10-15 хоногийн нөөцтэй, хамгаалах хувцас хэрэгсэл 7-14 хоногийн нөөцтэй байна.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

12 дугаар сарын Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 5081355.0 мян.төгрөг төвлөрүүлэхээс 5220426.0 мян.төг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 100 хувьтай байна.

Улсын төвлөрсөн төсөвт 954400.0 мян төгрөг төвлөрүүлэхээс 1045796.0 мянган төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 100 хувьтай байна.

2020 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар татвар төлөгч ХК-1, ХХК-319, ББН-5, ЗБН-9, Хоршоо-28, ОНӨҮГ-6, Салбар-74, Хадгаламж зээлийн хоршоо-1, Төсөвт байгууллага-57, ТББ-95, Шашны байгууллага-5, Сан-10, ОНБ-15 бүртгэгдэн, нийт хуулийн этгээд 625 болж, 4.6 хувиар нэмэгдсэн.

Орон нутгийн төсвийн байгууллагуудад 8206.9 сая төгрөг, Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад 9333.6 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн санд 1016.0 сая төгрөгийн зарцуулалтын эрх төсвийн хуваарийн дагуу бүрэн нээгдэж төрийн сангийн гүйлгээ хэвийн явагдаж байна.

Санхүүгийн хяналт, аудитын чиглэлээр: Баянтал сумын ЗДТГазрын 2018-2019 оны, 5 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар нийт 20887.7 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 3208.4 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн акт тогтоосон.

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Архивын ажлын чиглэлээр: Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 666 заалт, 8271 хүний нэр, 978 байгууллагын нэр, 980 газар зүйн нэр, 1535 хуудас баримтыг программд холбож, 1521 хуудас баримтыг засварлан, 1521 хуудас баримтыг скайнердаж цахим архив үүсгэсэн.

Архивын баримтаас 11 иргэнд лавлагаа мэдээлэл олгох үйлчилгээ үзүүлсэн.

Иргэний бүртгэлийн чиглэлээр нийт 133 иргэнд үйлчилгээ үзүүлсэн. Үүнд:

- Иргэний үнэмлэх шинээр олгосон -37
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо- 72

- Нас барсныг бүртгүүлсэн тоо - 4
- Өөр аймаг, хотоос шилжиж ирсэн нийт иргэн -12
- Аймаг дотор шилжсэн иргэдийн тоо -21

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 6
- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 8
- Гэрээний бүртгэл -13
- Барьцааны гэрээний бүртгэл -72

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл -2
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт -15

Архивын чиглэлээр:

- Хуулийн этгээдэд гаргасан лавлагаа, хуулбар -48
- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар - 85

Цагдаагийн хэлтэс нь: Цагдаагийн хэлтэс нь 2020 оны 12 дугаар сард иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 38 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгасан байна.

Урд оны мөн үеэс гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 9-өөр буюу 45 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 3-аар буюу 6.8 хувиар, нийт гомдол мэдээлэл 26-аар буюу 40 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Шинэ төрлийн коронавирусын цар тахлаас урьдчилан сэргийлэх бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан хорио цээрийн дэглэмийн үеэр байнгын болон явуулын 5 постонд 19 байгууллагын 56, Баянтал, Шивээговь сумын 6 байгууллагын 26 төрийн албан хаагч тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудаас давхардсан тоогоор 98 алба хаагч хариуцсан нутаг дэвсгэрт эргүүлийн үүрэг гүйцэтгэсэн. Давхардсан тоогоор 320 алба хаагч 24 цагаар эргүүлийн үүрэг гүйцэтгэж зөрчил гаргасан 104 иргэнийг 15 685 000 төгрөгөөр торгож, согтуугаар зөрчил гаргасан 15 хүнийг эрүүлжүүлэх, 8 хүнийг шүүхээр баривчлуулж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 1 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хассан байна.

Жендерт суурилсан хүчирхийллийн эсрэг “Яг одоо” аяны хүрээнд 2020 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн ерөнхий газраас зохион байгуулсан цахим хуралд аймгийн 2 алба хаагч хамрагдсан.

Шүүхийн шинжилгээний алба: Хэргийн газрын үзлэгт 1 удаа ажилласан. Хэргийн газрын үзлэгийн болон эд мөрийн баримт, эрэн сурвалжлах, танин олуулах ажиллагаа, хэргийн газрын давтан үзлэг, нэгжлэг, цогцос задлан шинжлэх зэрэг ажиллагааны 98 кадр гэрэл зургийг боловсруулан холбогдох материалд хавсаргасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-425 дугаар нээлттэй хорих анги: Шинээр ирсэн 13 хоригдолд нийгэм сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлсэн.

Шинээр ирсэн хоригдлуудын хувцас хэрэглэлд анхаарч угаалга цэвэрлэгээг тогтмолжуулан ариутгал хийлгэн тараан олгож байна.

Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан цахим уулзалт зохион байгуулж байна. Тайлант сард 98 хоригдол ар гэртэйгээ цахим уулзалт зохион байгуулсан.

Тайлант сард төлбөрийн 283 гүйцэтгэх баримт бичгээс 155 гүйцэтгэх баримт бичгийн 1173690.2 мянган төгрөгийг бодитой биелүүлж гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 54.7 хувьтай байна.

Мэргэжлийн хяналтын газар нь: Сүмбэр суманд үйл ажиллагаа явуулж байгаа банкуудын салбар, тооцооны төвүүд, АТМ-уудад коронавирусь халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, халдвар хамгааллын дэглэм мөрдөж ажиллах талаар хүргүүлсэн улсын байцаагчийн зөвлөмжийн хэрэгжилтэд дэмжлэгт хяналт хийж, хяналтаар шаардлагатай газар зай барь тэмдэглэгээ, гар ариутгагч байрлуулаагүй, үйлчлүүлэгчдийн зай бариулаагүй зэрэг нийт 14 зөрчил илрүүлж, газар дээр нь 12 зөрчлийг арилгуулж, бусад зөрчлийг арилгуулах талаар заавар, зөвлөгөө өгсөн.

Тайлант сард Улаанбаатар хотоос татан авалтаар зөөвөрлөж буй тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт хийж иргэдийг тогтоосон 4 зогсоолд бууж ачаа авах, халдваргүйжүүлэлт хийхэд хяналт тавьж, хүн хоорондын зай бариулж, бөөгнөрөл үүсгэхгүйгээр зохион

байгуулав. Мөн жолооч нарын халдвараас сэргийлэх дэглэмийн хэрэгжилт, гар халдваргүйжүүлэгч, хамгаалах хувцас, хэрэглэл, маск, бээлийн нөөц, хэрэглээнд хяналт хийж 3 зөрчлийг газар дээр нь арилгуулав.

Аймгийн онцгой комиссоос хүргүүлсэн үүрэг чиглэлийн дагуу Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн хэлтсийн албан хаагч нартай хамтран бүх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа 88 ААНБ, иргэдийн үйл ажиллагаанд коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж халдвар хамгааллын дэглэм баримтлаж байгаа эсэхэд гэнтийн шалгалт хийв.

Шалгалтад хамрагдсан объектуудын 67% нь мэргэжлийн байгууллагаас хүргүүлсэн зөвлөмжийн дагуу коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх холбогдох арга хэмжээг хэрэгжүүлсэн хэдий ч зай барих тэмдэг, тэмдэглэгээг дутуу байрлуулсан, QR код байрлуулаагүй, улсын бүртгэлд бүртгэгдээгүй, баталгаажилтгүй халдваргүйтгэлийн бодис хэрэглэсэн, ажлын байр, тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ халдваргүйтгэл хангалтгүй, коронавирусын халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдаагүй ажилчин ажиллуулсан, ажилчид болон үйлчлүүлэгчдийн халууныг үзэж тэмдэглэдэггүй, үйлчилгээний ажиллах хүчин дутагдалтай зэрэг нийтлэг зөрчлүүд илэрч шалгалтаар халдвар хамгааллын дэглэм бүрэн мөрдөөгүй 29 газрын үйл ажиллагааг зөрчил арилгатал түр хугацаагаар зогсоов.

Хяналт шалгалтын хүрээнд:

МХБ-ын хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө болон цаг үеийн нөхцөл байдал, иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээллийн дагуу нийт 5 хяналтын чиглэлээр төлөвлөгөөт шалгалт 3, төлөвлөгөөт бус шалгалт 1, зөвлөн туслах үйлчилгээ 3-ыг тус тус хийж, улсын байцаагчийн зөвлөмж 13, дүгнэлт 5, албан шаардлага 16, акт 3, хяналт шалгалтын удирдамж 14-ийг тус тус боловсруулж хяналт шалгалтад хамрагдсан ААНБ-уудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Политехникийн коллежийн хоолны газрыг түрээслэн хүргэлтийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж буй иргэнээс ирүүлсэн хүсэлтийн дагуу ажлын байранд дэмжлэгт хяналт хийв.

Хүргэлтийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээг 2 мэргэжлийн тогооч, 1 туслах ажилтантай явуулах ба ажилчид эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ болон PCR-н шинжилгээнд бүрэн хамрагдаж, хариу сөрөг гарсан, хоолны газарт мэргэжлийн байгууллагаар ариутгал цэвэрлэгээ хийлгэсэн, хоолны цэс, технологийн карт боловсруулсан, хоолны түгээлт хийх нэг удаагийн аяга, халбага сав суулга, зөөврийн хайрцаг нь стандарт шаардлага хангасан, түүхий эд бүтээгдэхүүний баталгаажилттай нь хяналтаар тогтоогдож, халдвар хамгааллын дэглэм мөрдөж, шаардлага хангасан тул үйл ажиллагаа эхлүүлэхийг зөвшөөрч, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

МХЕГ-ын 2020 оны 01/13 тоот удирдамжийн дагуу нийтийг хамарсан баяр ёслолын үед урьдчилан сэргийлэх хяналт шалгалтанд хүнсний худалдаа үйлчилгээний 3 худалдааны төвийг хамруулав. Шалгалтаар хадгалах болон хэрэглэх хугацаа хэтэрсэн бүтээгдэхүүн илрээгүй. Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэсэн огноо байхгүй, халуун хэмжилт хийгдэхгүй, ариутгалын бодис найруулсан процент, заавар байхгүй, бүтээгдэхүүний үнэ бичээгүй зэрэг нийт 12 зөрчил илрүүлж, 67 хувийг газар дээр нь арилгуулсан.

Онцгой байдлын газар нь: Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой комиссоос гарсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг шуурхай хангуулах, Аймгийн Засаг даргын Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай 2020 оны А/358, Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай А\361 дугаар захирамж, Covid-19 илэрсэнтэй холбогдуулан зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай А/369 захирамж болон Аймгийн Онцгой комиссын хурлуудын шийдвэрийн хэрэгжилтийг хангах захирамж, тушаал, удирдамжийг алба хаагч бүрт танилцуулан ажилласан.

Гал түймэр унтраах, аврах 37 дугаарангийн өдөр тутмын болон 7 хоногийн хүчин чадлын мэдээг-2 удаа, гал унтраах ангийн захирагчийн сарын ажлын тайлан, гал түймрийн

шифрийн мэдээг цахимаар тус бүр 1 удаа Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газарт хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

Тус ангийн алба хаагчдын ажлын цаг ашиглалт, сахилга хариуцлага, албаны бэлтгэл, бэлэн байдал, цэргийн хэргийн мэдлэг, ур чадвар, цэрэгжилч жагсаалч байдлыг дээшлүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Шадар сайдын 155 дугаар тушаал “Тусгаарлан ажиглалт болон гэрийн ажиглалтыг зохион байгуулах түр журам” мөн 156 дугаар тушаал “Хот хоорондын зорчигч, тээвэрлэлтийг зохион байгуулах түр журам”-ыг удирдлага болгон 2020 оны 12 дугаар сарын 07-21-ний өдрийн хооронд Аймгийн Онцгой комиссын хурал 8 удаа, Онцгой комиссын гишүүдийн цомхтогосон хурал 7 удаа зохион байгуулан ажиллаж байна. Мөн ГХУХБайцаагч Дорноговь, Хэнтий аймгийн Бор-Өндөр сум болон Улаанбаатар хотоос ирсэн 14 автобус, 522 иргэнд хяналт тавьж бүртгэлийг хийж Эрүүл мэндийн газарт өгч ажилласан.

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэл цахилгааны төлбөр тэгэлсэнтэй холбогдуулан Онцгой байдлын газрын даргын баталсан удирдамжын дагуу ГТУХБ, ГХУХБ нар ОБГ-ын 18 алба хаагч, БЗӨБЦТС ХХК-ны 13 ажилтан хамтран Сүмбэр сумын гэр хорооллын 374 айл өрхөд галын аюулгүй байдал, цахилгаан хангамжийн галын аюулгүй байдлыг шалган ГТУХБ-ын шалган зааварлах хуудас өгч бүртгэл хөтлөн гарын үсгээр баталгаажуулан 1268 иргэнд цахилгааныг зохистой ашиглах, оргил цагаар хэт ачаалал үүсгэхгүй байх, галын аюулгүй байдлыг ханган ажиллах талаар заавар зөвлөгөө өгч, 2500 ширхэг гарын авлагыг тарааж ажиллалаа.

Тус Онцгой байдлын газрын www.go.nema.gov.mn цахим сайтад Коронавирус халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж, мэдээлэл 1, үйл ажиллагааны чиглэлээр 2, цаг агаарын мэдээ 1, галын аюулаас урьдчилан сэргийлэх мэдээлэл 1 нийт 5 удаагийн мэдээлэл байршуулан бөгөөд сайтад 12633 хүн хандалт хийсэн нь өмнөх 14 хоногоос 1047 хандалтаар нэмэгдсэн байна.

Говьсүмбэр аймгийн Онцгой байдлын газар фэйж хуудсанд Коронавируст халвараас урьдчилан сэргийлэх 30, байгууллагын үйл ажиллагааны талаар 25, цаг агаарын мэдээ, мэдээлэл 8, галын аюулаас урьдчилан сэргийлэх 5, нийт 68 удаагийн мэдээлэл байршуулан нийт 25866 иргэд хандалт хийсэн байна.

12 дугаар сарын 8-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын 209 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 12 дугаар сарын 11-ний өдрийн А/380 дугаар “гамшгаас хамгаалах Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг сунгах тухай” захирамжинд тусгагдсан аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагааг хэвийн горимд оруулахтай холбогдуулан Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, Гал түймрийн улсын хяналтын байцаагч нар аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 16 хүнс, бараа, бөөний төвд хяналт шалгалт зохион байгуулсан. Хяналт шалгалтаар аймгийн Засаг даргын захирамжид тусгагдаагүй цахилгаан бараа, хүүхдийн тоглоом, бичиг хэрэг, бараа болон ахуйн хэрэглээний малгай, оймс, бээлий ил тавьсан зэрэг зөрчил илэрсэн байна. 12 дугаар сарын 08-ны өдөр Баянтал суманд үйл ажиллагаа явуулдаг 2 хүнсний дэлгүүрт хяналт шалгалт зохион байгуулахад халуун хэмжигч байхгүй, бараа бүтээгдэхүүн зарсан, халдвар хамгааллын дэглэм сахин ажиллаагүй зэрэг зөрчил дутагдал илэрснийг Баянтал сумын Тамгын газрын даргад халдвар хамгааллын дэглэмийг сахиулах зөрчлийг арилгуулах талаар үүрэг өгч, 12 дугаар сарын 18-ны өдөр эргэн шалгалт хийхэд зөрчлийг арилгуулсан байсан.

Мөн байгууллагын угтах хэсэгт QR кодыг хэвлэн үйлчилгээ авч байгаа иргэдийн орох гарах хөдөлгөөнд хяналт тавин халдвар хамгааллын дэглэмийг сахин ажиллах зөвлөмж өгч ажилласан.

12 дугаар сарын 17-ны өдөр Сүмбэр сумын гэр хорооллын гудамжинд үйл ажиллагаа явуулдаг 11 хүнсний дэлгүүр, авто засвар угаалга үйлчилгээ явуулдаг 4 нийт 15 иргэн аж ахуйн нэгж байгууллагын галын аюулгүй байдал, цахилгаан хангамжийг шалган хяналт тавин илэрсэн зөрчил дутагдлыг арилгах гал түймрийн улсын хяналтын байцаагчийн шалган зааварлах хуудас бичиж заавар зөвлөгөө өгч ажилласан.

Онцгой байдлын газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдөр баталсан “Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, гэр хорооллын айл өрх, цахилгаан хангамж хяналт

шалгалт” удирдамжийн хүрээнд 2020 оны 12 дугаар сарын 17-18-ны онцгой байдлын газрын 18 алба хаагч, Цахилгаан дамжуулах сүлжээний 13 ажилтан алба хаагчид Сүмбэр сумын 1, 2, 3-р багт байрлах гэр хорооллын айл өрхөөр цахилгааны галын аюулаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хамтран зохион байгуулан ажиллав. Үзлэг шалгалтаар Сүмбэр сумын гэр хорооллын цахилгааныг хэт ачаалал үүсгэж болзошгүй айл өрхүүдийг голчлон нийт 374 айл өрхөд галын аюулгүй байдал, цахилгаан хангамжийн галын аюулгүй байдлыг шалган ГТУХБ-ын шалган зааварлах хуудас өгч бүртгэл хөтлөн гарын үсгээр баталгаажуулан 1268 иргэнд цахилгааныг хэрэгслийг зохистой ашиглах, оргил цагаар хэт ачаалал үүсгэхгүй байх, галын аюулгүй байдлыг ханган ажиллах талаар заавар зөвлөгөө өгч, 2500 ширхэг гарын авлагыг тарааж ажиллалаа. Аймгийн Онцгой комиссоос өгсөн үүргийн дагуу 2020 оны 12 дугаар сарын 24-ны өдөр Онцгой байдлын газрын 4, Мэргэжлийн хяналтын газрын 4, Цагдаагийн хэлтсийн 4 нийт 12 алба хаагч Сүмбэр сумын үйл ажиллагаа явуулж 88 объектод /Ковид-19/ халдварт цар тахлаас сэргийлэх хяналт шалгалт зохион байгуулан 29 аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоож зөрчил дутагдлыг арилгах үүрэг чиглэл өгч ажилласан.

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Боловсролын чиглэлээр: Цэцэрлэгийн багш ажилчид 11 дүгээр сарын 09-ний өдрөөс 12 дугаар сарын 11 хүртэлх хугацаанд нийт 352 цахим хичээл бэлтгэн хүргэсэн. Теле хичээлд нийт хүүхдүүдийн 82.5 хувь нь хамрагдсан байна.

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн теле хичээлийн үр дүн цаашид анхаарах асуудлаар 3 удаагийн онлайн хурал зохион байгуулсан. Онлайн хуралд 143 багш хамрагдсан.

12 дугаар сарын теле хичээлийн талаарх цахим судалгааг эцэг эхчүүдээс авсан. Тус судалгаанд 100 эцэг, эх хамрагдаж, судалгаанд оролцогч эцэг эхийн хүүхдүүдийн 57.4 хувь теле хичээлээ тогтмол үздэг, 20.7 хувь ихэвчлэн, 18.4 хувь заримдаа гэсэн хариулт өгсөн байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр: “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян”-ы хүрээнд 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс 12 дугаар сарын 10-ны өдрийн хооронд цахим хэлбэрээр зохион байгуулан, гэр бүлээрээ хүчирхийллийн айдасгүй амар амгалан орчинг бий болгохын төлөө гэр бүлдээ эерэг уур амьсгалыг бүрдүүлж, хүчирхийллээс ангид байх, аливаа хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 21 төрлийн постер, зөвлөмж, 17 видео шторкыг орон нутгийн төр, төрийн бус байгууллага, нийт 40 байгууллагын цахим хаяг, вэб сайтад нийтлэн аяны хугацаанд тасралтгүй иргэд, олон нийтэд мэдээлэл түгээж нийт давхардсан тоогоор 16 000 хүний хандалт авсан байна.

Соёл, урлагийн чиглэлээр: Боржигин чуулга шинэ жилийн баярыг тохиолдуулан “Тайзны зочин” тусгай хөтөлбөрт тоглолт нэвтрүүлгийг 12 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн өдөр бүр цахимаар үзэгчдэд хүргэж байна.

Боржигин өв музей нь Соёлын яамнаас уриалж буй “Цахим орчинд соёл түгээе” аяны хүрээнд “Боржигин байшин”, “Боржигин морин хуур”, “Боржигин уртын дуу”, “Боржигин найр” гэсэн сэдвүүдээр цахим танилцуулга бэлтгэн цахимаар түгээсэн. Нийт 10319 хүн боржигин өв соёлын мэдээлэлтэй танилцсан байна.

Эрүүл мэндийн чиглэлээр: Эрүүл мэндийн үзүүлэлт

Үзүүлэлт	2019 оны 12 сар	2020 оны 12 сарын 20-ны байдлаар
Төрсөн эх	427	422
Гэрийн төрөлт	0	0
Амьд төрсөн хүүхэд	429	427
Амьгүй төрөлт	0	0
Нас баралт	58	74
Эмнэлгийн нас баралт	10	4
Хоног болоогүй нас баралт	3	1
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	5	3

1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	2
Эмнэлгээс гарсан хүний тоо	4838	4226
Амбулаторийн үзлэг	97106	93910
Халдварт өвчин	166	70

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр: Тайлант сард аж ахуй нэгж, байгууллага, иргэнээс 8 сул ажлын байрны захиалга ирүүлсний дагуу Говьсүмбэр ажлын байр цахим хуудсаар болон иргэдэд утсаар санал болгож, 4 иргэнийг ажлын байранд зуучлаад байна.

Ажил хайгч, ажил олоход хүндрэлтэй, их, дээд болон мэргэжлийн боловсролын сургууль төгссөн 4 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө өгөн, ажил хайгчаар бүртгэсэн.

Хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд 33 иргэн шинээр бүртгэгдсэн байна.

Нийгмийн халамжийн чиглэлээр: 2020 оны 12 дугаар сарын байдлаар нийгмийн халамжийн сангаас дараах хөнгөлөлт, үйлчилгээнүүдийг үзүүллээ. Үүнд:

- Нийгмийн халамжийн тэтгэвэр 287 хүнд 741.1 сая төгрөг
- Нөхцөлт мөнгөн тэтгэмж 297 иргэн 237.2 сая төгрөг
- Жирэмсэн хөхүүл, хүүхэдтэй эх, өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэмж 1454 хүнд 409.1 сая төгрөг
- Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж 1076 хүнд 94.2 сая төгрөг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн хөнгөлөлт тусламж 291 хүнд 53.0 сая төгрөг
- Алдарт эхийн 1, 2-р одонтой эхчүүдийн мөнгөн тусламж 1288 хүнд 169.1 сая төгрөг
- 65-аас дээш настай ахмадуудад насны хишиг олголт 719 хүнд 113.5 сая төгрөг
- Хүнс тэжээлийн тусламж 721 хүнд 147.5 сая төгрөг
- Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 282 хүнд 214.5 сая төгрөг
- Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжийг 7 хүнд 15.0 сая төгрөг
- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг 223 хүнд 16.8 сая төгрөг тус тус зарцуулсан.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Мал, аж ахуйн чиглэлээр: Аймгийн засаг даргын 2020 оны А/127 дугаар захирамжаар мал сүрэгт үзлэг ангилалт хийх, цөм сүрэг бүрдүүлэх, ялган тэмдэглэх ажил хийгдэж дууссан. Нийт 5906 хонь ангилалтад хамруулснаас цөм сүрэгт 2567 буюу 43.5 хувь, үржлийн сүрэгт-1457 буюу 24.7 хувь, хэрэгцээний сүрэгт 1882 буюу 14.6 хувь нь ангилагдсан байна. Цөм сүрэгт ангилагдсан хонийг 100 хувь ээмэгжүүлсэн.

12 дугаар сарын 07-ны өдрийн байдлаар аймаг дундын Малх отрын бүсэд 7 аймгийн (Говьсүмбэр, Дундговь, Өвөрхангай, Төв, Баянхонгор, Хэнтий, Завхан аймаг) 22 сум, Улаанбаатар хотын 3 дүүрэг, нийт 166 өрхийн 140218 толгой малтай (хонин толгойд шилжүүлснээр-187583 толгой) өвөлжиж байна. Энэ нь бэлчээрийн даацаас 54583 толгой буюу 41 хувиар хэтрэлттэй байна. Мөн отрын бүсээс гадна Дундговь, Өвөрхангай, Баянхонгор, Улаанбаатар хотын 63 өрхийн 53658 толгой мал отроор байна.

Үйлдвэр, худалдаа үйлчилгээ: 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар: Аймгийн дүнгээр мах 45.9 тн буюу 28 хоног, гурил 68.6 тн буюу 49 хоног, сүү 2.05 тн буюу 1 хоног, төрөл бүрийн будаа 23.1 тн буюу 33 хоног, төмс 38.8 тн буюу 23 хоног, хүнсний ногоо 36.6 тн буюу 10 хоног, элсэн чихэр 4.7 тн буюу 10 хоног, давс 3.6 тн буюу 13 хоног, савласан ус 22.1 тн буюу 1 хоног, өндөгний нөөц 0.4 тн буюу 1 хоног, ургамлын тос 5.6 тн буюу 18 хоногийн нөөцтэй байна.

2020 онд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас зээл хүссэн 21 аж ахуй нэгжийн 3.3 тэрбум төгрөгийн 21 төслийг Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу шалгаруулж, 6 аж ахуйн нэгжид 448 000 000.0 төгрөгийн зээл олгосон.

Тус 6 ААНэгжийн үйл ажиллагааны чиглэлээр нь ангилбал:

- Аялал жуулчлал-1
- Нарлаг хүлэмжний аж ахуйн чиглэлээр-1

- Мах хадгалах, зоорийн аж ахуйн чиглэлээр-1
- Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах чиглэлээр-1
- Мах, махан бүтээгдэхүүн боловсруулах чиглэлээр-1
- Сав баглаа боодлын чиглэлээр-1 авсан байна.

Эдгээр төслүүдийн хүрээнд 24 ажлын байр бий болно.

**Аймгийн төвийн захууд, томоохон худалдааны төвүүдийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийг өнгөрсөн сарын үнэтэй харьцуулан гаргасан
2020 оны 12 дугаар сарын үнийн мэдээ**

Зах зээлд худалдаалагдаж буй Үхрийн ястай, цул махны үнэ 500-100 төгрөгөөр, хонины ястай, цул махны үнэ 500-1000 төгрөгөөр, лууван 200 төгрөгөөр, төмс 100 төгрөгөөр, сонгино 200 төгрөгөөр, будаа 200 төгрөгөөр, Алтан тариа 1-р гурил /задгай/ 20 төгрөгөөр, ургамлын тос 250-300 төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Бусад бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна.

№	Бараа бүтээгдэхүүн	Дээд үнэ төг	Доод үнэ төг	Өссөн буурсан	
1	Үхрийн мах	Ястай	8500	8000	+1000
		Цул	10500	10000	+500
2	Хонины мах	Ястай	6500	6000	+500
		Цул	9000	8000	+1000
3	Адууны мах	Ястай	6000	5500	-
		Цул	6500	6000	-
4	Ямааны мах	Ястай	6000	5500	-
		Цул	6500	6000	-
5	Тахианы мах	Гуя	10500	7900	
		мөч	8000	7900	
6	Лууван	Монгол	1500	1100	+200
		Хятад			
7	төмс	Монгол	1200	900	+100
		Хятад			
8	Байцаа	Монгол	800	600	-
		Хятад			-
9	чинжүү	Монгол	7500	7000	-
		Хятад	6500	4500	
10	Манжин	Монгол	2000	1500	
		Хятад			-
11	Сонгино бөөрөнхий	Монгол	2600	2300	+200
		Хятад	1500	1400	-
12	Улаан лооль	Монгол	6000	5500	-
13	Өргөст хэмх	Монгол	7500	6500	-
14	Элсэн чихэр	Монгол	2200	1600	-
15	Будаа	Цагаан задгай кг	2600	2400	+200
		Шар слава кг	3500	3000	-
		Гурвалжин будаа кг	3800	2200	-
16	Сүү	Задгай	3200	3000	-
		Сүү ХХК 0,5л			
		Сүү ХХК 1л	3200	2900	-

17	Тараг	Задгай	2200	2000	-
		Сүү ХХК 1л цөцгийтэй тараг	4800	3800	-
18	Талх	Чойр талх	1200	1150	-
19	Өндөг	ОХУ	400	360	-
		Монгол	400	330	-
20	Алтан тарианы гурил	Задгай дээд	1520	1480	
		Задгай 1-р зэрэг	1140	1100	+20
		Задгай 2-р зэрэг	1000	950	-
		Савласан д/дээд /	2400	2300	-
		Савласан дээд	2200	2100	-
		Савласан 1-р зэрэг	1400	1300	-
		Савласан 2-р зэрэг	1500	1450	-
21	Ургамлын тос	Олейна	5500	5200	+300
		Алтан	4500	4500	+250
22	Гоймон	Алейка	1800	1600	-
		А/тариа савхан	1100	950	-

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр: Аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн зардлаар аялал жуулчлалын гол маршрутын дагуу Зүүн Чойрын хийд, Хүүхдийн овооны дэргэд албан ёсны тайлбар бүхий Монгол, Англи орчуулгатай гантиг чулуун мэдээллийн самбарыг байршуулах ажлыг “Боржигин нутгийн зураг” ХХК-иар гүйцэтгүүлээд байна.

2020 онд аймгийн цөлжилтийн судалгааны ажлыг Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 8 сая төгрөгөөр “Биологийн олон янз байдлын төв” нийтэд үйлчлэх төрийн бус байгууллагаар хийлгэж хүлээн аваад байна. Судалгааны дүнгээр нийт нутаг дэвсгэрийг цөлжилтийн зэрэглэлээр ангилж үзэхэд 44.1 хувь нь маш хүчтэй, 55.1 хувь нь хүчтэй, 11.4 хувь нь сул зэрэглэлд хамрагдаж байгаа бөгөөд 0.8 хувьд нь газрын доройтол илрээгүй байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны тогтоолын дагуу 2020 онд мод бутны урамшуулал авах шаардлага хангасан 1 аж ахуй нэгж байгууллага, 17 иргэний тарьсан 1979 мод бутанд Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 18.9 сая төгрөг олгосон.

“Чойрын богд” Улсын тусгай хамгаалалттай газарт байршдаг зэрлэг амьтан болох аргаль хонинд био техникийн арга хэмжээнд зориулан 2021 оны хавар ашиглах 100 боодол өвс худалдан авч нөөцлөөд байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/112 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж, цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан аж ахуйн нэгж, байгууллагуудын 2020 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлантай танилцах хурлыг 2020 оны 12 сарын 18-ны өдөр цахимаар зохион байгууллаа.

Ус, цаг уур, орчны шинжилгээний ажлын хүрээнд: 12 дугаар сард азотын давхар исэл (NO₂) болон хүхэрлэг хийн давхар ислийг (SO₂) хоногт 3 удаагийн давтамжтайгаар сорьцыг 42 удаа хийж, мөн шинжилгээг 14 удаагийн дээжинд хийхэд азотын давхар исэл (NO₂) 0.013

мкг/мг, хүхэрлэг хийн давхар исэл (SO₂) 0.022 мкг/мг байгаа нь хүлцэх агууламжаас хэтрээгүй байна.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар: Газрын кадастрын мэдээллийн санд аймгийн хэмжээнд өмчлөлийн 9038 нэгж талбарт газрын үл хөдлөх хөрөнгийн албан татварыг ногдуулалтыг үүсгэсэн. Үүнд:

- Сүмбэр сум 5856 нэгж талбар
- Баянтал сум 1505 нэгж талбар
- Шивээговь сум 1677 нэгж талбарт тус тус татварын ногдуулалтыг үүсгэсэн.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/281 тоот захирамжийн дагуу газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дахин дуудлага худалдааг 2020 оны 12 сарын 21-ний өдөр 2 байршилд зохион байгуулж дуудлага худалдааны мэдээллийг нийтэд мэдээлсэн.

Баянтал, Шивээговь сумдын 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хянаж, газар зохион байгуулалтын төлөвлөлтийн цахим системд баталгаажуулсан.

Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системд Сүмбэр, Баянтал, Шивээговь сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан хаягийн тогтоолыг нэг бүрчлэн оруулан ажиллаж байна. Үүнд:

- Шивээговь сумын 34 гудамж
- Баянтал сумын 114 гудамж
- Сүмбэр сумын 38 гудамж

Мөн Шивээговь сумын Уурхайчдын гудамжны 1-4 дүгээр эгнээг хаягийн мэдээллийн санд оруулан ажиллаж байна. Шивээговь суманд төлөвлөлтөөр олгогдсон гэр бүлийн хэрэгцээний зориулалттай өмчлөлийн газруудад хаяг өгөх ажлыг Шивээговь сумын газрын даамал гүйцэтгэн ажиллаж байна.

Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн www.urban.gov.mn цахим хуудсанд Сүмбэр сумын цэвэр усны шугам 23350 м, ариутгах татуурга 10398 м, дулаан хангамж 9546 м зэрэг гол магистрал шугамуудыг 100 хувь бүртгэсэн.

Худалдан авах ажиллагааны талаар: 2020 онд улсын төсвийн хөрөнгөөр 10 ажил хийхээр төлөвлөсөн. 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 9 ажлын тендер шалгаруулалтыг зарласнаас 9 бараа ажил үйлчилгээний ажил дуусч ашиглалтад хүлээн авсан, 1 тендер шалгаруулалтыг зогсоосон.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 31 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 31 ажлын тендер шалгаруулалт зарлаж, 27 бараа ажил үйлчилгээний ажил дуусч ашиглалтад хүлээн авсан, 3 ажлын тендер шалгаруулалтыг зарласан боловч амжилтгүй болж 2021 онд зарлуулахаар шилжүүлж Төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд оруулж батлуулсан. Авто замын сан, Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 5 ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулж ажлыг 100 хувь гүйцэтгүүлсэн.

ДОЛОО. СУМ ОРОН НУТГИЙН ТАЛААР

Сүмбэр сум: Сүмбэр сумын Засаг даргын 2020 оны 12-р сарын 15-ны өдрийн А/207 дугаар захирамжаар 2020 оны хүн ам, мал тэжээвэр амьтдын тооллогын комиссыг 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрөөс 12 дугаар сарын 26-ны өдрийг хүртэл халдвар хамгааллын дэглэмийг нарийн чанд сахиж ажиллах талаар үүрэгжүүлэн тооллогын ажил эхлэлээ. Хөдөөгийн 3 багт 3 автомашин 12 тоологч, төвийн 3 багт 33 тоологч ажиллаж байна.

Сүмбэр суманд эрсдэлд нөхцөлд амьдардаг 236 хүүхэд, хоол хүнсний дутагдалд орох магадлалтай 55 өрхийн судалгааг гарган аймгийн Онцгой комисст хүргүүлэн ажилласан. Монголын улаан загалмайн нийгэмлэг, Аймгийн онцгой комисстой хамтран сумын 46 өрхөд 1380000, аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүнд нөхцөлд амьдардаг 20 өрхөд 538000, Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжүүд аймгийн Онцгой комисстой хамтран 150 өрхөд 5205000 төгрөгийн хүнсний тусламж, Мөн 115 өрхөд 135 тонн нүүрсний тусламжийг тус тус үзүүлсэн.

Хот тохижилтын ажлын хүрээнд Сумын Засаг даргын нөөцөөс 3209000 төгрөг, сумын Байгаль хамгаалах хөтөлбөр арга хэмжээний “Золбин нохой, муур устгах ажил” арга хэмжээний зардлаас 1612000 төгрөгийн зардлыг гаргаж 1, 2, 3 дугаар багийн нутаг дэвсгэрт нохой устгалын ажлыг зохион байгуулж 248 нохой, 13 муур устгаж, төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүллээ.

Шивээговь сум: Сумын Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/211 дугаар захирамжаар “2020 оны жилийн эцсийн хүн ам, мал тэжээвэр амьтдын тооллого”-ын ажлыг зохион байгуулах комисс 24 хүний бүрэлдэхүүнтэй томилогдож, комиссын гишүүддээ хүн ам, мал тооллогын сургалт зохион байгуулж 12-р сарын 16-ны өдрөөс тооллогын ажил эхэлж 12-р сарын 24-ний өдрийн байдлаар адуу-1195, үхэр-924, тэмээ-173, хонь-14706, ямаа-17196 нийт 34194 толгой мал тоологдож, урьдчилсан байдлаар 891 өрхийн 2948 хүн ам, тоологдоод байна. Тооллогын ажил 71 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

Сумын ИТХ-ын 2 дугаар хуралдаан 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулагдаж сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, сумын 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө, сумын 2021 оны төсвийн төслийг тус тус хэлэлцэн баталлаа.

Сумын Онцгой комиссын хурлыг 12 дугаар сард 18 удаа зохион байгуулж коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг аймгийн Засаг даргын 2020 оны А/356, 363, 364 дүгээр захирамжуудын дагуу Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж хүн болон тээврийн хэрэгслийн орох, гарах хөдөлгөөнд хяналт тавьж суманд 4 пост ажиллаж байсаныг 2020 оны 11-р сарын 28-аас 2 пост болгон 12-р сарын 28-ны өдрийг хүртэл 24 цагийн жижүүр гарган ажиллаж байна. Мөн МУ-ын Шадар сайдын 2020 оны 146 дугаар тушаалын дагуу аймаг нийслэлээс Шивээговь суманд ирэх болон сумаас зорчих хүсэлтэй иргэдийн судалгааг гарган ажилласнаар 12 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар 218 иргэн ирж тусгаарлалтанд 7 хоног байж давтан шинжилгээнд 159 иргэн хамрагдаад байна.

Монгол улсыг бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан сумын амжиргааны баталгаажих түвшинээс доогуур орлоготой болон зорилтот бүлгийн давхардсан тоогоор 48 өрхөд 45 тн буюу 1,604,064 төгрөгийн нүүрс, 115 өрхөд 5, 726, 264 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүний тусламжийг олгоод байна.

Илчлэг-Шивээ ОНӨҮГ-ын ундны усны эх үүсвэр болох алсын 1, 2 дугаар худагын насост гэмтэл гарч 500м3 цэвэр усны нөөцийн сан хоосорч 24 цаг тэг зогсолт хийсэнтэй холбогдуулан сумын Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/204 дугаар захирамжаар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж хөлдөлт үүсгэхгүйн тулд аймгийн Ус-Ду ОНӨҮГ, Төмөр замын цэрэгжүүлсэн бэлэн байдалтай тусгай анги, ШОХК, Баянтал сумын Талын илч ОНӨҮГ, Онцгой байдлын газар зэрэг байгууллагууд техник хэрэгсэл, хүн хүчээр хамтарч ажилласаны үр дүнд гэмтэлийг олж алсын худагт шинэ 2 насос суулган сумыг 72 цагийн дотор ус, халаалтаар ханган хэвийн үйл ажиллагаанд оруулсан. Одоогоор халаалт өгөх –70, буцах – 60 температуртай байна.

Сумын Эрүүл мэндийн төвд Улсын онцгой байдлын газрын нөөцөөс УИХ-ын гишүүн Г.Мөнхцэцэг түргэн тусламжийн машиныг 2020 оны 12-р сарын 03-ны өдөр хандивлалаа.

Коронавирусийн улмаас 2020 оны 11-р сарын 11-ний өдрөөс ЕБСургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг цахимаар зохион байгуулж теле хичээлд гэрээсээ хамрагдаж байгаатай холбогдуулан ЕБС-ын багш нар өдөр бүр ангийн сурагчидтайгаа эргэх холбоотой ажиллаж байна. 12-р сарын байдлаар нийт сурагчдын 70-аас дээш хувь нь теле хичээлээ цаг тухайд нь хийдэг. 20 орчим хувь нь нөхөн тооцуулдаг бол үлдсэн 10 орчим хувь нь теле хичээлд цаг тухайд нь үзэх боломжгүй учир багшийн өгсөн даалгаврыг хийж 7 хоногтоо 1 удаа багштайгаа холбогдож байна.

ЕБСургууль багш нарынхаа дунд хамт олноороо монгол бичигтэн болох сарын аяныг 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн өрнүүлээд байна.

БСШУЯ-ны сайдын А/162 тоот тушаалын дагуу сургууль, цэцэрлэгийн хэмнэгдсэн хүнсний нөөцийг сумын хагас, бүтэн өнчин болон хөгжлийн бэрхшээлтэй, зорилтот бүлгийн 44 өрхөд 29 нэр төрлийн 1,6 сая төгрөгийн үнэ бүхий хүнсний бүтээгдэхүүний дэмжлэг үзүүлсэн. Мөн 5 өрхөд түлээ нүүрсний дэмжлэг үзүүлсэн.

Багш бүр теле хичээл үзүүлэх болон цэцэрлэгийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр гарын авлага ном тараах, өөрсдийн бэлтгэсэн хичээлийг бүлэг бүрийн групп хуудасаар дамжуулан хүргэх ажлуудыг зохион байгуулж 12 төрлийн даалгаврын ном боловсруулан 1003 ширхэгийг тараан ажиллуулсан нь нийт хүүхдийн 89.3 %-ийг хамруулаад байна.

Аймагт тохиолдол илэрсэнтэй холбогдуулан 2020 оны 11-р сарын 17-оос эхлэн иргэдээс хамар залгиураас хурдавчилсан, PCR шинжилгээнүүдийг авч 2020 оны 12 сарын 24-ний өдрийн байдлаар хурдавчилсан оношлуураар нийт- 1650 иргэн, PCR –365 иргэн шинжилгээнд хамрагдаснаар сумын нийт өрхийг 100 хувь хамруулсан.

Сумын Засаг даргын 2020 оны 10-р сарын 20-ны өдрийн А/171 дугаар захирамжийн дагуу Шүлхий, хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг 2020 оны 10-р сарын 21-ний өдрөөс эхлэн зохион байгуулж Шүлхийн вакцинд 65 өрхийн 57539 толгой мал, хонины цэцэгийн вакцинд 58 өрхийн 8923 толгой мал, галзуугын вакцинд 3 өрхийн 2323 толгой малыг тус тус 100 хувь хамруулсан байна.

Дундговь аймгийн Эрдэнэдалай, Луус, Адаацэг, Дэлгэрхангай сумдаас 11 малчин өрхийн бог 8063, бод 583 нийт 8646 толгой мал сумын нутаг дэвсгэрт оторлож байна.

Золбин нохой, муур устгах ажлыг Улаанбаатар хотын иргэн Б.Будтай гэрээ байгуулан “Байгаль орчин, эрүүл ахуй орчны бохирдлыг бууруулах – Хоггүй сум” дэд хөтөлбөрийн 2 сая төгрөгийн хөрөнгөөр 2020 оны 11-р сарын 27, 28-ны өдрүүдэд зохион байгуулж 77 нохой, 33 муурыг устгаж булсан.

2020 онд ОНХС-ийн 297962200 төгрөгийн хөрөнгөөр нийт 5 ажил, 3 бараа, 3 зөвлөх үйлчилгээ, 6 төсөл хөтөлбөр төлөвлөснөөс 5 ажил, 3 бараа, 2 зөвлөх үйлчилгээний ажлыг тендер шалгаруулалтын журмын дагуу зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулан 1 зөвлөх үйлчилгээний ажил гэрээний гүйцэтгэлийн шатандаа явагдаж байна. 2020 оны 9-р сарын 25-нд төсөвт тодотгол хийгдэж төлөвлөгөөнд 2 ажил нэмэгдсэн тул өөрчлөлт оруулан батлуулж тус 2 ажил, 1 зөвлөх үйлчилгээний ажлыг 2021 онд хийж гүйцэтгэхээр онд дамжуулаад байна.

2021 онд ОНХС-ийн хөрөнгөөр 21 ажлыг 306 510 900 төгрөгөөр хийж гүйцэтгэхээр батлуулсан.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР